

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг «Studia Philosophiae Et Juris» буюу «Философи, эрхийн судлал» сэтгүүл нь 1967 оноос тогтмол хэвлэгдсээр 49 дахь жилдээ 40 дэх дугаараа эрхэм уншигч танд хүргэж байна.

«Studia Philosophiae Et Juris / Философи, эрх зүйн судлал» эрдэм шинжилгээний цуврал сэтгүүл нь философи, социологи, шашин судлал, эрхзүй, улс төр болон бодлого судлалын чиглэлээр нийгмийн тулгамдсан болон суурь асуудлуудыг судлан нийтэлдэг мэргэжлийн сэтгүүл болон төлөвшиж ирсэн билээ.

Улмаар нийгмээ оношлох, зураглах, цэгнэн дүгнэх шинжлэх ухаанч, философи хандлагыг чиг баримжаагаа болгож ирсэнд энэхүү сэтгүүлийн үнэ цэнэ оршиж байдаг. Сэтгүүл түүхэндээ нэрээ бага зэрэг өөрчилж ирсэн түүхтэй бөгөөд энэ жилийн хувьд ч бид уугуул нэр болох “Философи, эрхийн судлал” хэмээх нэрийг сэргээн хэрэглэхээр Эрдмийн зөвлөлийн хурлаараа шийдвэрлэсэн болно. Сэтгүүлийн чанар, нэр хүндийг өргөх үүднээс тус сэтгүүл нь академик хараат бус, судалгааны ёс

зүйг эрхэмлэсэн, олон ургальч үзэл хандлагыг дээдэлсэн, философи төдийгүй салбар дундын судалгааны талбар болохуйц сэдэв бүхий эрдэм шинжилгээний өгүүллүүдийг хянан магадлаж, редакторуудын зөвшөөрлөөр хэвлэж байна.

Энэхүү дугаарт экологийн философи, шашны социологи, харьцуулсан логик, шашны олон янз байдал, төрийн онол, төр, засгийн бодлого, эдийн засгийн шинжилгээ бүхий асуудлыг хамарсан судалгааны өгүүллүүдийг нийтэлж байна. Нийтлэлүүд нь сонгодог болон орчин үеийн онолын хандлагыг Монголын нийгэм, эдийн засаг, нүүдлийн болон аж үйлдвэржилтийн нөхцөл байдалтай холбон шинжилсэн байдал нь тус сэтгүүлийн энэ удаагийн дугаарын онцлог юм.

Сэтгүүлийн зорилго бол илүү чанартай, шат дараалан өртөөлсөөр өндөр зэрэглэлийн эрдэм шинжилгээний нэр хүнд бүхий сэтгүүл болоход орших бөгөөд үүний тулд талуудын хамтын ажиллагаа юу юунаас чухал болохыг онцолж байна.

Эрдэм номын үйлс дэлгэрч, шинэ мэдлэг мэдээллийг түгээн дэлгэрүүлцгээе.

*Профессор Б.Пүрэвсүрэн*  
*Ерөнхий редактор*